

**БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ – 2021**

2022.04.01

Зорилго: Говь ХК-ийн байгаль орчин, нийгэм, засаглалын /БОНЗ/ үйл ажиллагааны тайланг ерөнхий байдлаар дүгнэх зорилготой.

Хамрах хүрээ: Говь ХК-ийн бүхий л үйл ажиллагаа

БОНЗ-ын үйл ажиллагааны тайланг тогтвортой хөгжлийн удирдлага, байгаль орчин, нийгэм, засаглал, салбарын онцлог гэсэн 5-н үндсэн хэсэгт хуваан авч үзсэн. Түүний дагуу дараах байдлаар дүгнэлт гаргаж байна.

1. Тогтвортой хөгжлийн удирдлага

Бид тогтвортой хөгжлийн хүрээнд БОНЗ-ын нөлөөллийг бууруулах, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн болон олон улсын сонирхогч талуудын хүсэл шаардлагад нийцэх сонирхлоор 2021 оны 11-р сард Тогтвортой хөгжлийн газрыг шинээр үүсгэн байгуулсан. Энэхүү газар нь байгууллагын тогтвортой хөгжлийн үүрэг амлалт, бодлого, зохицуулалтыг боловсруулан хэрэгжүүлж, гүйцэтгэлийг сонирхогч талуудад тогтмол тайлагнан ажиллаж байна. Сонирхогч талуудын тогтвортой хөгжлийн мэдлэг, чадварыг тогтмол хөгжүүлэх зорилгоор, сургалт контент хөгжүүлэлтийг хийж байна. Мөн БОНЗ-ын нарийвчилсан үнэлгээг хийлгэж гарч буй индикаторуудыг нарийн тодорхойлон сайжруулалтын арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллана. Цаашид тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй хамтран ноос ноолуурын үйлдвэрлэлийн салбарын БОНЗ-ын үйл ажиллагааг сайжруулахад манлайлан оролцох болно.

2. Байгаль орчин

Бид үйл ажиллагаандаа ISO 14001:2016 Байгаль орчны удирдлагын тогтолцоо нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид хүрэн эрчим хүчний хэрэглээг бууруулж сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг тасралтгүй нэмэх зорилго тавин ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд хүлэмжийн хийн ялгаралын эсрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж мод тарих, эрчим хүч хэмнэлт хийх, хог хаягдлаа ангилан ялгах, дахин ашиглах зэрэг ажлуудыг хийсээр ирсэн ба уур амьсгалын

өөрчлөлтийн эсрэг төр, дотоодын болон олон улсын нэгдэлүүдтэй хамтран ажиллах замаар байгаль орчны нөлөөллүүдийг тасралтгүй багасгана.

3. Нийгэм

- Говь ХК нь хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, эрх тэгш байдлыг хангаж ажиллахад онцгойлон анхаардаг бөгөөд ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаанд нэвтрүүлэн хэрэгжүүлсний үр дүнд бид 2021 онд үйлдвэрлэлийн осолгүй ажилласан.
- Эрх тэгш байдлыг хангах бодлогыг хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжилтийг хангадаг ба ялгаварлан гадуурхах, жендерийн эрх тэгш байдлыг хангах журам хэрэгжүүлэн ажилладаг. Нийт ажилтнуудын 70%-ийг эмэгтэйчүүд эзэлдэг ба дундаж цалин хүйсийн хувьд тэнцүү хэмжээнд байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй 18-н ажилтан одоогоор ажиллаж байгаа нь нийт ажилтны тоонд харьцуулахад 1% орчим байна. Энэхүү хувийг 2%-д хүргэхийг зорин ажиллана. Мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, болон сонирхогч талуудын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх ажлуудыг хэрэгжүүлнэ.
- Ажилчид, олон нийтийн санал гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, мэдээлэл өгөх тогтолцоо хөгжсөн бөгөөд цаашид илүү сайжруулан ажиллана.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд томоохон хөтөлбөрүүд санаачлан хэрэгжүүлэхээр зорьж байна.
- Одоогоор бид худалдан авалтын бодлогодоо ногоон худалдан авалтыг дэмждэг бөгөөд цаашид тогтвортой өртгийн сүлжээний байгууллагын дотоод стандартыг бий болгон, хэрэгжилтийг ханган, тасралтгүй сайжруулна.

4. Засаглал

- Байгууллагын засаглалын үйл ажиллагааг зохицуулах тухайлсан бодлого, дүрэм, журмуудтай ба хэрэгжилтийг тогтмол хангаж ажилладаг.
- Цаашид бид үйл ажиллагаандаа комплаенсын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн хэрэгжүүлж, бизнесийн ёс зүй, хууль эрх зүйн нийцлийг ханган ажиллана. Мөн шүгэл үлээх тогтолцоог дотооддоо нэвтрүүлнэ.
- 2022 онд ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн хэрэгжүүлж байгууллагын бүхий л үйл ажиллагааны түвшинд процессийн шинэчлэлт сайжруулалт, гүйцэтгэлийн үзүүлэлтийг шинэчлэн тогтоох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

- Эрсдлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж ажилладаг бөгөөд үйл ажиллагааны бүхий л эрсдлийг үнэлэн, хариу арга хэмжээг төлөвлөн тогтмол мониторинг хийн ажиллаж байна.

5. Салбарын үйл ажиллагаа

- Тогтвортой бэлчээр, мал аж ахуйд анхаарал хандуулан ажилладаг.
 - Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл болон Европын сэргээн босголт хөгжлийн банк, "Говь" ХК нар хамтран "Малчны хотноос Дэлхийн брэнд" төслийг 2019-2021 оны хооронд хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд бэлчээр ашиглах зохистой дадлын сургалт болон хөндлөнгийн үнэлгээний ажлыг шат дараалалтай хэрэгжүүлсэн.
 - Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төслийг ХААИС, малчидтай хамтран 2020 оноос эхлэн санаачлан хэрэгжүүлж байна. Энэхүү төсөлд Баянхонгор аймгийн Жинст сум, Хөнөг, Хүйс баг, Хөвсгөл аймаг, Их Уул сум, Асгат багуудад үйлдвэрлэл – шинжлэх ухаан - малчид хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх зорилготой.
- Ногоон шошго, гэрчилгээжүүлэлтийн хувьд:
 - Швейцарь улсын Цюрих хотод төвтэй ОЕКО-ТЕКС байгууллагын "STANDARD 100 by Oeko-Tex" стандартын шаардлагыг хангаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын гэрчилгээг 2 дахь жилдээ Ээрмэл утсанд авсан.
 - Их британи улсад төвтэй Тогтвортой ноос ноолуурын эвсэл / SFA байгууллагын "Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал"-ын тохирлын үнэлгээнд 2 дахь удаагаа амжилттай хамрагдаж "Алтан батламжлал" гардан авсан.
 - Ямааны ноолууран "Н-1, 02, 03, 57 кодтой утас нь химийн будаггүй, цайруулалтгүй ба эдгээр утсаар хийгдсэн сүлжмэл, нэхмэл, оёмол бэлэн бүтээгдэхүүн нь үйлдвэрлэлийн менежмент, чанарын үзүүлэлтүүд органик хөдөө аж ахуй гаралтай бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг ханган "Органик бүтээгдэхүүн" гэрчилгээгээ дахин сунган ажиллаж байна.
 - Цаашид бид салбарын тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг сайжруулахын тулд төрийн болон төрийн бус байгууллагуудтай тасралтгүй хамтран ажиллах болно. Мөн тогтвортой түүхий эд хөтөлбөрийг хэрэгжүүлэн 2025 он гэхэд 100% тогтвортой түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэн хэрэглэгчийн гарт хүргэх болно.

Тайланг дүгнэсэн:

Тогтвортой хөгжил хариуцсан захирал  А.Цэрэнтогтох - 2

Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга  Э.Ивгээл

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайлан нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудын байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн стратеги, арга хэмжээ, нөхцөл байдлыг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд ил тод нээлттэй тайлагнах зорилготой.

Хэсэг 1, 2, 3 нь нийт үнэт цаас гаргагч компаниудад хамааралтай бөгөөд Хэсэг 4 нь зөвхөн тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас гаргагчдад хамаарна.

Хэрэв тайлангийн маягтад заасан аливаа мэдээллийг цуглуулах, тайлагнах боломжгүй бол тайлагнах боломжтой талаарх тайлбар, цаашид мэдээллийг тайлагнах чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тайлбар хэсэгт бичнэ үү.

Огноо (он, сар, өдөр):	3/20/2022
Үнэт цаас гаргагчийн нэр:	Говь ХК
Үнэт цаасны нэр, код (МХБ симбол):	GOV
Салбарын ангилал:	Үйлдвэрлэл
Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	
Тайлангийн хамрах хугацаа:	2021/01/01-2021/12/31
Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас:	А.Цэрэнтогтох, Тогтвортой хөгжил хариуцсан захирал, cso@gob.tn, 99092787
Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):	Ч.Солонго, Таруун дэд захирал
Гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн даргын гарын үсэг:	



Бүлэг	Шалгуур үзүүлэлт	Үзүүлэлт (2021 он)	Хэмжих нэгж	Нэмэлт мэдээлэл	Тайлбар	Холбоос
Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд						
MS1.1	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Үгүй	1.Тийм 2.Үгүй	Тогтвортой хөгжлийн хувьд байгууллагын одоогийн төлөв байдлыг тодорхойлох ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа. Тодорхойлсон төлөв байдалд тулгуурлан үүрэг амлалт, бодлого, зорилго, зорилтыг боловсруулж байна.	Боловсруулагдаж байгаа. GRI 102
MS2.1	Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Үгүй	1.Тийм 2.Үгүй		Боловсруулагдаж байгаа. GRI 103, ISO 14001
MS2.2	Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Үгүй	1.Тийм 2.Үгүй		GRI 103, ISO 14001
MS3.1		ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Үгүй	1.Тийм 2.Үгүй		GRI 102
MS3.2		Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	1.Тийм 2.Үгүй	2021 оны 11-р сард байгууллагын хэмжээнд Тогтвортой хөгжлийн газрыг шинээр үүсгэн байгуулсан. Үүнд Тогтвортой хөгжлийн хэлтэс мөн Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал, байгаль орчны хэлтэс хамаардаг. Компанийн тогтвортой хөгжлийн цаашдын бодлого, зорилго, зорилтуудыг тодорхойлон хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг оролцогч болон сонирхогч талуудад тайлагнаж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг сайжруулна.	GRI 102
MS3.3	Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	1.Тийм 2.Үгүй	2021 оны 11-р сард Тогтвортой хөгжлийн хэлтсийг байгуулсан. Энэхүү хэлтэс нь Тогтвортой хөгжил, Удирдлагын тогтолцоо, Комплаенс, Эрсдэлийн удирдлага гэсэн хүрээнд компанийн одоогийн төлөв байдлыг тодорхойлж, богино-дунд-урт хугацааны зорилго, зорилтуудыг боловсруулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	GRI 102	
MS3.4	Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	2022 оноос эхлэн ТУЗ-ийн төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн асуудлыг жилд 3-н удаа хэлэлцэхээр оруулсан.	GRI 102	
MS3.5	Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Үгүй	1.Тийм 2.Үгүй		SASB
MS4.1	Чадавч бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	14648 хүн/цаг	хүн/цаг	2022 онд тогтвортой хөгжлийн хүрээнд 14648 хүн/цагийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн.	GRI 102
MS4.2	Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Үгүй	1.Тийм 2.Үгүй		GRI 102, SDG 12
MS4.3	Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	2021 онд компанийн жилийн тайланд тогтвортой хөгжлийн тайланг нэгтгэн тайлагнасан. 2022 оноос тогтвортой хөгжлийн тайлангийн загварыг боловсруулж, оролцогч талуудад тогтмол тайлагнана.	GRI 102, SDG 12
MS5.1	Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг уу?	Үгүй	1.Тийм 2.Үгүй		GRI 102, SDG 12	
MS5.2	Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	1. Хөдөө аж ахуйн их сургууль, Малчин, "Говь" ХК нар хамтран "Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"-ийг 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь Үйлдвэрлэл-Малчин-Шинжлэх ухаан хоорондын уялдаа холбоог бэхжүүлж малын эрүүл мэнд, арчилгаа, маллагаа, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж гүйцэтгэх, малчдад ямааны ноолуур бэлтгэлийн технологийн зөв дадал эзэмшүүлэх замаар ноолууран түүхий эдийн чанарыг сайжруулах, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой. 2. Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл /Sustainable Fibre Alliance/ болон Европын сэргээн босголт хөгжлийн банк, "Говь" ХК нар хамтран "Малчны хотноос Дэлхийн брэнд" төслийг 2019-2021 оны хооронд хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд Монгол улсын нутаг дэвсгэрийн бэлчээрийн доройлтыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, зэрлэг амьтныг хамгаалах, ноолуурын тогтвортой аж ахуйг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахад зогсохгүй зохистой дадлыг батламжлах тогтолцоог Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын "Дэлгэрэхийн Улаан Ямаа" хоршоо, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын "Залаа Жинст Торгон Сүрэг" хоршоонд тус тус нэвтрүүлж, чанартай ноолуур бэлтгэн нийлүүлэх чадвар, чадамжтай болоход дэмжлэг үзүүлэн ажилласан. 3. Текстилийн Салбарын Тогтвортой Үйлдвэрлэл ба Эко Тэмдэг Төсөл /STEPECOLAB/, Монголын Ноос Ноолуурын Холбоо хамтран "Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн сайн дурын үйл ажиллагааны дүрэм"-ийг боловсруулан 2021 онд гаргасан. Бид Монголын текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн дүрмийн нөхцлүүдийг хүлээн зөвшөөрч, байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай тогтвортой үйлдвэрлэл явуулахаа илэрхийлэн уг дүрэмд нэгдсэн.	GRI 102, SDG 17
MS6.1	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд					
E1.1	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	8802 Mega Втц	Mega Втц '000	УБЦТС, ТЭЦ-3-ын төвийн шугамаас нийт эрчим хүчний эх үүсвэрийг авдаг. 2021 онд нийт 1,725,166,909кВт-ийг эрчим хүчний хэрэглээнд зарцуулсан.	GRI 302, SDG 12
E1.2	Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	1. Нийт зарцуулалтын хэмжээ-8775 Mega Втц 2. Хэмнэлт-497 Mega Втц	Mega Втц '000	Үйлдвэрийн орчинд 530ш эрчим хүчний хэмнэлтэй лед гэрэлтүүлэг, 165ш хөдөлгөөн мэдрэгчтэй гэрэл тус тус суурилуулсан. Агааржуулалтын 55-75 квт-ын моторуудад давтамж хувиргуур суурилуулсан. 5,6%-ийн хэмнэлт гаргасан.	GRI 302, SDG 12
E1.3	Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	Нийт зарцуулалтын хэмжээ-22313 Гкал	BTU & % Гкал	Хэмнэлт хийсэн ажил одоогоор байхгүй.	GRI 302, SDG 12

E1.4	Эрчим хүч	Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	1. Нийт зарцуулалтын хэмжээ-40298.82 литр	Литр/кг & %, ГЖоуль, Төгрөг	Байгууллагын үйл ажиллагаанд ашигладаг автобус, автомашин жилд 3,487,193.1тн CO хүлэмжийн хий ялгаруулсан. /Ажилтнуудын тээврийн хэрэгслийг автобус болон хайбрид автомашинаар шийдсэнээр нийт ялгарах хүлэмжийн хийг бууруулсан/	Түлшний нийт хэмнэлтийн хэмжээг хувиар тооцох боломжгүй.	GRI 302, SDG 12	
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь		%	УБЦТС ТЭЦ-3-ын төвийн шугамаас ЦЭХ худалдан авдаг.	Хүрэн эрчим хүчний хэрэглээний хувийг тооцох боломжгүй.	SFRD	
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь			%	Гадаа талбайн гэрэлтүүлэг нарны эрчим хүчээр ашигладаг гэрэлтүүлэгтэй.	СЭХ-ний хэрэглээний хувийг тооцох боломжгүй.	GRI 302, SDG 7
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	16,865,337	CO2/тонн	2021 оны ЦЭХ, ДЭХ, түлшний хэрэглээнээс хамаарч жилд нийт 16,865,337.0 тн хүлэмжийн хийг шууд болон шууд бус байдлаар ялгаруулсан.		GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.	
E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	32,493,386.29	тонн	Говь ХК-ын нийт 1500 ажилтнууд жилд автомашинаар ирж буцах хугацааг тооцвол нийт 35,980,579.404 тн CO2 хүлэмжийн хий ялгаруулна. Харин байгууллагын хэмжээнд нийт ажилтнуудыг автомашин, автобусаар зөөвөрлөснөөр 3,487,193.1тн хүртэл хүлэмжийн хийг бууруулсан тооцоо гарсан. Ингэснээр жилд нийт 32,493,386.29 тн хүлэмжийн хий ялгаруулсан.		GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.	
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт) бууралт	51,903 тн	CO2/тонн	Байгууллагын хэмжээнд нийт 790 ширхэг мод тарьж суулгасан. Нийт 51,903 тн хүчилтөрөгч ялгаруулж хүлэмжийн хийн хэмжээг бууруулсан.		GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.	
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Үгүй	1.Тийм 2.Үгүй	Тогтвортой хөгжлийн бодлогод тусган хэрэгжилтийг хангана.	Боловсруулагдаж байгаа.	GRI 201, TCFD, SDG 13	
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү?(сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Үгүй	1.Тийм 2.Үгүй			GRI 201, TCFD, SDG 13	
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	0	Төгрөг		Байхгүй	GRI 201, TCFD, SDG 13	
E3.4	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	MNT 85,796,086	Төгрөг	Эрчим хүч хэмнэлт Эрчим хүчний аудит хийлгэх, эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс зохион байгуулсан сургалтанд хамрагдах, байгууллагын инженер техникийн ажилтнуудыг сургалтанд хамруулж чадавхижуулах, үйлдвэрийн зарим нэгжүүдийн гэрлийг эрчим хүчний хэмнэлттэй гэрлээр солих, шат болон коридорт фото хөдөлгөөн мэдрэгчтэй гэрлүүдийг суурилуулах, агааржуулалтын моторуудад инвертор суурилуулах, үйлдвэрийн гадна гэрэлтүүлгийг нарны зайн гэрлээр солих зэрэг ажлуудад 78,666,086₮ зарцуулсан. Мод тарих Нийт 790 ширхэг мод тарьж суулгасан. 51,903 тн хүчилтөрөгч ялгаруулж хүлэмжийн хэмжээг бууруулсан. Энэ ажилд 7,130,000₮ зарцуулсан.		GRI 201, TCFD, SDG 13	
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон үү?	Үгүй	1.Тийм 2.Үгүй		Боловсруулагдаж байгаа.	GRI, SASB, World Economic Forum	
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	163.5 мян.м3	м3/л	2021 онд 163.5 мян.м3 ус ашигласан.		GRI 303, SDG 6	
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	3.8 мян.м3	м3/л	2021 онд агааржуулалтын хөргөлтийн уснаас 3.8 мян.м3 усыг анхан шатны угаах үйлдвэрт ашигласан бөгөөд нийт усны хэрэглээний 2.3% болж байна.		GRI 303, SDG 6	
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	2.3%	%	2.3%		GRI 303, SDG 6	
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	16.6 мян.м3	м3/л	Анхан шатны угаах үйлдвэрийн хаягдал 16.6 мян.м3 усыг цэвэрлэх байгууламжаар цэвэрлэж төвийн шугамд нийлүүлсэн.		GRI 303, SDG 6	
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	167.92тн	тонн	Нийт 2021 онд 167.92тн хог хаягдлыг гарсан. Хог хаягдлыг эх үүсвэрээр нь дахивар, цаас, бусад гэж ангилдаг. Ялгах хогийн савыг нийт үйлдвэр, оффисын хэмжээнд дотор талбайд 34 байршилд 174 ширхэг, гадна талбайд 4 байршилд 12 ширхэг тус тус байршуулсан. "Эко орчин" ХХК-тай хог тээвэрлэлтийн гэрээ байгуулан 2018 оноос эхлэн хамтран ажиллаж байна.		GRI 306, SDG 12	
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	20%	%	2021 онд нийт 102 удаагийн рейсээр 1,3 тн цаасан хаягдлыг "Агар тайж" ХХК-д, 523 кг гялгар уут, хуванцар савыг "Мулти пак" ХХК-д тус тус тушаасан. 22.8 тн буюу нийт хог хаягдлын 20%-ийг дахин боловсруулах цэгт тушаасан.		GRI 306, SDG 12	
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)	2 тонн	тонн	2021 онд гарсан нийт аюултай хог хаягдлын хэмжээ 2 тонн гарсан. Халдвартай хог хаягдлыг шар уутанд, хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг аюулгүйн хайрцагт тус тус цуглуулж автоклавт 105 оС-ийн температурт 30-аас багагүй, 121 оС-ийн температурт 20-оос багагүй эсвэл 134 оС-ийн температурт 10-аас багагүй минутын хугацаанд халдваргүйжүүлсний дараа боломжтой бол буталж, боломжгүй бол буглалгүйгээр лангфилд булж устгана. Химийн бодисын сав, баглаа боодол устгал хийлгэх ажлыг БОАЖЯ-ны тусгай зөвшөөрөлтэй "Цэцүүх трейд" ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд 1474 ширхэг хуванцар сав болон баглаа боодол, 317 ширхэг төмөр лаазыг мэргэжлийн байгууллагад шилжүүлсэн.		GRI 306, SDG 12	
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	7	%	Оффисын гадна талбай, цайны газрын урд талбай, цайны газрын хойд хаалганы хажуу тал, байгууллагын баруун тал зэрэг газруудад модлог ургамал хайлаас, нохойн хошуу, улиас, голт бор зэрэг модод суулгасан. Эдгээр зүлэгжүүлсэн талбай нь нийт талбайн 7%-ийг эзлэж байна.		GRI 304, SDG 15	
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо	Байхгүй	Төрөл зүйлийн тоо			GRI 304, SDG 15	
E6.3		Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээслэсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	Байхгүй	%			SFRD, IFC Performance Standard 6	
Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд									
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	51	%	2022.03 сарын байдлаар ажлын байрны сэлгээ 51% гарсан. Үүнд 2021 оны цомхотгол нөлөөлсөн.		GRI 401, SDG 8	
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	31	Тоо	Өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинээр 31 ажлын байр шинээр бий болсон бөгөөд 2021 онд нийт 467 хүн ажилд орсон байна.		GRI 401, SDG 8	
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	19.9	цаг	1. Давтагдсан тоогоор нийт 3998 ажилтан 113 удаагийн давтамжтайгаар нийт 211.5 цагийн сургалтанд хамрагдсан. Нэг ажилтанд жилд дундаар 19.9 цагийн сургалт хийгдсэн. 2. Сургалтын эх үүсвэрийг: 1. Дотоод эх үүсвэрээс авах сургалт 2. Гадаад эх үүсвэрээс авах сургалт гэж 2 ангилна. 3. Төрлөөр нь: 1. Чиглүүлэх сургалт 2. Мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх сургалт 3. Амёб менежментийн сургалт 4. ХЭМАБ-ын нийт ажилтны сургалт 5. Ерөнхий ур чадварын сургалт гэж ангилна.		GRI 401, SDG 8	

S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	1.Тийм 2.Үгүй	2020.03.27-ны өдөр батлагдсан "Б20-ХЭМАБ-БОХ-01-03" дугаартай "Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны бодлого" хэрэгжиж байна. Бид үйл ажиллагаандаа "НЭГДҮГЭЭРТ АЮУЛГҮЙ БАЙДАЛ" зарчмыг баримтлан Монгол улсын хууль тогтоомжийг чанд мөрдөн, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг удирдаж, зөв зохистой нөөцөөр ханган, ажлын орчин нөхцөлийг сайжруулан, нийт ажилтнуудын оролцоог хангах замаар ХЭМАБ-ын мэдлэг, чадамжийг нэмэгдүүлнэ.	GRI 103, SDG 10
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	0	%	2021 онд Үйлдвэрийн осол-0, хугацаа алдсан гэмтэл-0 байлаа. 1. Эрсдлийн үнэлгээг жилд 1 удаа 2. Ажилтан тухай бүрт аюулыг мэдээллийг хуудсаар осол, гэмтлийг мэдээллэх 3. Тухай бүрт хяналт буюу ээлжит давтан зааварчилгаа хийх 4. Мөн ослын талаарх мэдээллийг тогтмол мэдээллэх замаар үйлдвэрийн осол болон хугацаа алдсан гэмтлийг 0 байлгах арга хэмжээг авч байна.	GRI 403, SDG 3
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	3.8	хүн/цаг	Жилд нэг ажилтанд 3.8 хүн/цагийн сургалт, зааварчилгаа хийгдсэн.	GRI 403, SDG 3
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	4987+1322	хүн	2021 онд амбулаторын үзлэг нийт 4987 удаа хийгдсэн. Ковид 19 халдварыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ нийт 1034 удаа хийгдэж, үүнээс 220 аерэг тохиолдол илэрсэн. Шинэ ажилтны үзлэг-495, уламжлалт, физик эмчилгээ-791, яаралтай тусламж-4, тариа-817, дусал-853, боолт-111 удаа тус тус хийгдсэн. Эрүүл мэндийн хугацаат үзлэгийг жил бүр улсын болон хувийн эмнэлэгтэй хамтран зохион байгуулдаг. 2021 онд Улсын хоёрдугаар төв эмнэлэгтэй хамтран, компанийн нийт 1336 ажилтнаас 1322 ажилтныг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, гүйцэтгэлийн дүн 99% гарсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд илэрсэн өвчлөлийн байдлыг давхардсан тоогоор дүгнэж үзвэл: Дотор судлал-1138 / Чих хамар хоолойн-737 / Эмэгтэйчүүд-1051 / Мэс засал-72 / Хавдрын сэжигтэй тохиолдол-7 / Ковидын дараах хам шинж-47 / Жирэмсэн эмэгтэй-25 тохиолдлууд тус тус илэрсэн. Ажилтнуудын дунд хугацаат үзлэгээр түгээмэл илэрсэн өвчний жагсаалтыг үндэслэн "Эрүүл мэнд хөтөлбөр"-өөр сургалт болон урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулдаг.	GRI 403, SDG 3
S3.1	Эрх тэгш байдал	Жендэрийн бодлого, журам	Жендэрийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Жендэртэй холбоотой тусгайлан журам шинээр боловсруулж байгаа бөгөөд Хөдөлмөрийн дотоод журманд ерөнхий заалтууд тусгагдсан байдаг.	GRI 405, SDG 5
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг тусгайлан журам шинээр боловсруулж байгаа бөгөөд Хөдөлмөрийн дотоод журманд ерөнхий заалтууд тусгагдсан байдаг.	GRI 103, SDG 5
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Ялгаварлан гадуурхалтын эсрэг тусгайлан журам шинээр боловсруулж байгаа бөгөөд Хөдөлмөрийн дотоод журманд ерөнхий заалтууд тусгагдсан байдаг.	GRI 103, SDG 10
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эрэгтэй 30% Эмэгтэй 70%	%	Нийт 1527 ажилтантай бөгөөд: Эрэгтэй 463 буюу 30% Эмэгтэй 1064 буюу 70% эзлэж байна.	GRI 405, SDG 5
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эрэгтэй 44% Эмэгтэй 56%	%	ТУЗ-ийн нийт 9 гишүүнтэй бөгөөд: Эрэгтэй 4 буюу 44% Эмэгтэй 5 буюу 56% эзлэж байна.	GRI 405, SDG 5
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эрэгтэй 38% Эмэгтэй 62%	%	Захиралуудын зөвлөлд нийт 16 захирал байгаа бөгөөд: Эрэгтэй 6 буюу 38% Эмэгтэй 10 буюу 62% эзлэж байна.	GRI 405, SDG 5
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эрэгтэй 30% Эмэгтэй 69%	%	ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын түвшнээс бусад түвшинд: Эрэгтэй 453 ажилтан буюу 30% Эмэгтэй 1049 ажилтан буюу 69% эзлэж байна	GRI 405, SDG 5
S3.8		Жендэрт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	Эмэгтэй 1.25 Эрэгтэй 1.09	харьцаа	2021 онд ажилтнуудын дундаж цалингийн харьцаа: Эмэгтэй 1.25 Эрэгтэй 1.09	Байгууллагын эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж цалин Монгол улсын 2021 оны 4-р улиралын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж цалинтай харьцуулсан харьцаа
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Үгүй	1.Тийм 2.Үгүй	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд зориулсан бодлого, журам байхгүй.	SDG 10
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	1%	%	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнээр бүртгэлтэй нийт 18 ажилтан байгаа бөгөөд нийт ажилтнуудын 1% эзлэж байна.	SDG 10
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	Тийм	1.Тийм 2.Үгүй	Төв оффис руу орох, гарах хаалганд тэргэнцэртэй иргэнд зориулсан гарц хийсэн.	SDG 10
S4.4		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо	Байхгүй	Тоо	Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилладаг.	SDG 10
S5.1	Нийгмийн харьцуулах ба ил тод байдал	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлан бодлого байгаа юу?	Үгүй	1.Тийм 2.Үгүй	Оролцогч талуудыг бүхлээр нь хамарсан хамтран ажиллах бодлого байхгүй. Харин бэлтгэн нийлүүлэгчидтэй харилцах харилцааг зохицуулсан Худалдан авалтын бодлого байдаг.	IFC
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	Үгүй	1.Тийм 2.Үгүй	Байхгүй.	IFC Performance Standards
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	1. 2020.02.28-ны өдөр батлагдсан Ж20-3АА09-02 дугаартай "Оролцогч талуудын өргөдөл, санал, гомдол хүлээн авах журам" хэрэгжиж байна. 2. 2022 оны 3 сард энэ журам нь шинэчлэгдэж байгаа ба одоогоор батлагдах шатандаа явж байна. 3. Газар, нэгж хэлтсүүдээс нэгтгэл тайлан ирдэг бөгөөд Архив, санал гомдлын мэргэжилтэн аван, хяналт тавидаг.	GRI 102, SDG 16
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Санал гомдлыг дараах хэлбэрээр авч байна : 1. Салбар дэлгүүрүүдээс 2. Хими цэвэрлэгээний газраас 3. Чанар стандарт баталгаажуулалтын албанаас 4. Гадаад борлуулалтын хэлтсээс 5. 99905357 дугаарт 6. Complaint Viber-т 7. Хүний нөөц захиргааны газраас 8. Санхүү стратегийн газраас Дээрх газруудаас 10 хоног тутамд нэгтгэл тайланг Архив, санал гомдлын мэргэжилтэн авдаг ба сар бүрийн эхний 5 хоногт нэгтгэл тайланг гаргадаг. Ингэснээр шийдвэрлэлтэнд 10 хоног бүр давхар хяналт тавин ажилладаг. Мөн шийдвэрлэгдсэн үед хэрэглэгч нарт хариу мэдэгддэг.	IFC Performance Standards

S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	99.3	%	2021 онд нийт 3822 гомдол гарсан түүний 3799 гомдлыг шийдвэрлэсэн. Мөн 2022 оны 2 сараас эхлэн тогтолцооны хувьд залруулах хариу арга хэмжээ авахаар ажиллаж байна.	GRI 413, SDG 8
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь	0.02%	%	1. Хүүхдийн төв сувилалын байнгын асаргааны хүүхдүүд, хэвтэн эмчлүүлж буй багачуудад, Шинэ найдвар ТТБ-ын асрамжийн газрын нийт 200 гаруй бэлгийг өгсөн. 2. 2021.01-12 сар Компанид үр бүтээлтэй олон жил ажиллан тэтгэвэрт гарч буй болон ахмад ажилтнуудыг баярлуулах арга хэмжээ зохион байгуулсан.	GRI 413, SDG 8
S6.1		Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжыг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	1.Тийм 2.Үгүй	1. 2021.07.26 өдөр батлагдсан Б21-ХАХХ-01-07 дугаартай "Худалдан Авалтын Бодлого"-ын 5 дугаар зүйлд тогтвортой хөгжлийн зорилгод чиглэсэн, ногоон худалдан авалтыг дэмжсэн харилцагчид тавигдах нөхцлүүдийг тусгасан. 2. 2021.11.30 өдөр батлагдсан Ж21-ХАХХ-01-07 дугаартай "Захиалга хүлээн авах, худалдан авах, хүлээлгэн өгөх журам"-ын 4.7 зүйл, 6.1 зүйл, 7.1, 11.1 зүйлүүдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн худалдан авалтын нөхцлүүдийг тусгасан.	GRI 204, SDG 8
S6.2	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	62.9%	%	Одоогоор Монгол, Хятад, Япон, Солонгос, Европын зах зээлээс нийт 213 ханган нийлүүлэгчид хамтран ажиллаж байна. Дээрхи ханган нийлүүлэгчдийн 62.9% буюу 134 нь дотоодын ханган нийлүүлэгчид байна. Эдгээрээс 20%-30% нь эмэгтэй бизнес эрхлэгчид байна.	GRI 204, SDG 8
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	20%	%	Бүтээгдэхүүнд ашигладаг туслах материал, худалдаалагдаж буй бэлэн бүтээгдэхүүний сав баглаа нь дахин ашиглах зориулалт бүхий байгальд ээлтэй материалаар хийгддэг. GOTS хангасан будгийг будах үйлдвэрт ашигладаг. *Ханган нийлүүлэгчдээс авч байгаа нийт худалдан авалтын дүнд байгаль орчинд ээлтэй сав баглаа болон хувцасны будгийн нийт өртөг 20%-ийг эзлэж байна.	GRI 204, SDG 8
Засаглалын шалгуур үзүүлэлтүүд							
G1.1	Авилгал болон ёс зүй	Авилга, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авилгын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	2018.11.01 өдөр батлагдсан "Ёс зүйн дүрэм" мөн 2021.09.27 өдөр батлагдсан "Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам" хэрэгжиж байна. Ёс зүйн дүрэм болон Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмын сайжруулалтыг 2022 оны 2-р улиралд хийхээр төлөвлөж байна.	GRI 205, SDG 16
G2.1	Компанийн засаглал	Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	55.56%	%	Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 9 гишүүний 5 гишүүн нь хараат бус гишүүд байдаг. Хараат бус гишүүд нь дараах үндсэн үүрэгтэй: - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх; - Зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлвэл уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх; - Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагаас шаардах, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах; - Хувьцаа эзэмшигчдийн хуралд бичлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ талаар мэдээллэж, хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулах, тодруулга хийх;	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.2		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	2021.04.16 өдөр ТУЗ-өөс баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам" мөн 2018.07.09 өдөр баталсан "Мэдээллийн үйл ажиллагааны журам" байдаг. Хувьцаа эзэмшигч нарт хүргэх мэдээллийг цаг тухай бүрт хүргэн, ил тод байдлыг ханган ажиллахаас гадна санал хүсэлтийг нь хүлээн авч шуурхай хариу өгөн шийдвэрлэн ажилладаг.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.3		Компанийн засаглалын бодлого, журам	Компанийн засаглалын бодлого, журам бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Компанийн засаглалын дүрэм журмуудыг нэгтгэсэн баримт бичиг байдаг (2020.04.24 өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 02 дугаар тогтоолын хавсралт). Энэхүү батлагдсан дүрэм журмын хүрээнд компанийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод чиг үүргээ хэрэгжүүлэн тогтмол хуралдаж, шийдвэр гарган хяналт тавьж ажилладаг. Ногдол ашгийн бодлого, эрсдэлийн удирдлагын бодлого, дотоод хяналтын бодлогуудын хүрээнд засаглалыг хэрэгжүүлэн ажиллахаас гадна, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг ханган мэдээллийн ил тод байдлыг сахин ажилладаг.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?	Үгүй	1.Тийм 2.Үгүй	Комплаенсын бодлогыг 2022.03 сард боловсруулагдаж буй бөгөөд санал авах үйл ажиллагаа явагдаж байна.	Боловсруулагдаж байгаа GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	Үгүй	1.Тийм 2.Үгүй	2022.04 сард комплаенсын хөтөлбөрийг боловсруулна. Хөтөлбөрт комплаенсын бодлого, зорилго, шаардлагатай журмууд болон хэрэгжүүлэлт, сургалт түгээлт, хянах сайжруулах үйл явцыг тусгасан байна. Зөрчлийн талаар мэдээлэх журмыг 2022.06 сард батлуулахаар төлөвлөсөн бөгөөд холбогдох тогтолцоог хэрэгжүүлнэ. Оролцогч талуудын өргөдөл, санал гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журамтай.	Боловсруулагдаж байгаа GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү)							
FS1	Санхүүгийн үйлчилгээ	Санхүүгийн хүртээмж	Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр	0	Хүн	Байхгүй	SDG 1
FS2		БОНЗ-ын эрсдэлийн менежмент	БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний хувь	0	%	Байхгүй	Mongolian Sustainable Finance Principles
FS3		Тогтвортой санхүүжилт	Нийт зээлийн багцад эзлэх ногоон/ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой зээлийн эзлэх хувь	0	%	Байхгүй	SDG 13, Mongolia Green Taxonomy
A1		Устгалын бодис	Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	2021.10.07 өдөр батлагдсан "Аюултай хог хаягдал устгах журам" хэрэгжиж байна.	GRI 403, SDG 12

A2	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Тогтвортой газар, бэлчээр	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь	%	%	1. Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл болон Европын сэргээн босголт хөгжлийн банк, "Говь" ХК нар хамтран "Малчны хотноос Дэлхийн брэнд" төслийг 2019-2021 оны хооронд хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд бэлчээр ашиглах зохистой дадлын сургалт болон хөндлөнгийн үнэлгээний ажлыг шат дараалалтай хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд С002 бэлчээр ашиглах зохистой дадлын олон улсын мөнгө, хүрэл гэрчилгээнүүдийг дараах сумдууд аван баталгаажуулсан. - Баянхонгор аймгийн Шинэжинст сум 170 өрх мөнгөн гэрчилгээ, 35 өрх хүрэл батламж - Дорноговь аймгийн 36 өрх мөнгөн батламж тус тус авсан. 2. "Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл" Баянхонгор аймгийн Жинст сум, Хөвсгөл, Хүйс баг Хөвсгөл аймаг, Их Уул сум, Асгат багуудад үйлдвэрлэл-шинжлэх ухаан-малчид хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх төслийг 2020 оноос эхлэн хэрэгжүүлж байна.	Төсөл хэрэгжсэн газрын бэлчээрийн талбайн хувийг одоогоор хэмжих боломжгүй.	SDG 12
A3		Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь	0.06%	%	2021 онд нийт 576,007 ширхэг бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Үүнд : Сүлжмэл бүтээгдэхүүн - 473,936ш Нэхмэл бүтээгдэхүүн - 72,007ш Оёмол бүтээгдэхүүн - 30,064ш Ковид-19 цар тахлын улмаас 2020 онтой харьцуулахад үйлдвэрлэлийн хэмжээ 58%-аар буурсан. Хэрэглэгчээс бэлэн бүтээгдэхүүнтэй холбоотой нийт 547ш гомдол ирсэн. Үүний 386ш / 71% нь үйлдвэрээс шалтгаалсан гомдол, бусад шалтгаанаар 161ш /	Үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүний нийт тоонд үйлдвэрээс шалтгаалсан гомдлыг харьцуулсан хувь	GRI 416, SDG 12
T1	Текстиль	Тогтвортой мал аж ахуй	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг нэвтрүүлсэн малын тоо, бэлчээрийн эзлэх хувь		но. & %	1. "Малчны хотноос Дэлхийн брэнд" төслийн хүрээнд малчдад мал аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх ажлуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан. Үүнд малчны хариуцлагыг дээшлүүлж, мал амьтны эрхийг хамгаалах таван эрх чөлөөний зарчмыг даган мөрдөхөд анхаарч, олон улсын ноолуурын чиглэлийн аж үйлдвэрлэлийн хүрээнд тохируулан нийцүүлсэн болно. Зохистой дадлын шалгуур үзүүлэлтүүдэд тэжээл ба усан хангамж, мал маллах орчин, арчилгаа маллагаа, малын эрүүл мэнд, ноолуур самнах, ноолуур бэлтгэх, тээвэрлэхтэй холбоотой шаардлагууд төдийгүй эрсдэлийг бууруулах зэрэг үзүүлэлтүүд багтсан болно. Энэ ажлын үр дүнд С001 мал аж ахуй эрхлэх ноолуур бэлтгэх зохистой далын олон улсын гэрчилгээг дараах сумдууд аван, баталгаажуулсан. - Баянхонгор аймгийн Шинэжинст сум 205 өрх хүрэл батламж - Дорноговь аймаг Дэлгэрэх сум 36 өрх хүрэл батламж тус тус авсан. 2. "Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"-ийн хүрээнд сумдуудын бэлчээрийн тогтвортой байдлыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг сайжруулах, ямааны тоо толгойноос илүү нэг ямаанаас гарах гарцын үнэлгээг сайжруулах мөн мэдээллийн сан үүсгэхэд анхаарч ажиллаж байна. 2021 оны байдлаар Баянхонгор аймаг Жинст сум, Хөвсгөл аймаг Их Уул сумдуудын нийт ямааны тоо толгой 4,335 гарсан.		GRI 403, SDG 12
T2		Тогтвортой аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн	Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандартын (MNS 6926:2021) дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо, эзлэх хувь	0	но. & %	Байхгүй	GRI 416, SDG 12	
T3		Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам	Тийм	1.Тийм 2.Үгүй	2021.10.07 өдөр батлагдсан "Химийн хортой болон аюултай бодис захиалах, худалдан авах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах журам" хэрэгжиж байна.	GRI 403, SDG 12	
MA2		Дахин боловсруулсан материал	Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь	0	%	Одоогоор байхгүй	SDG 12	
MA3		Ногоон шошго, гэрчилгээжүүлэлт	Эко буюу ногоон шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний эзлэх хувь	0	%	1. Швейцарь улсын Цюрих хотод төвтэй OEKO-ТЕКС байгууллагын "STANDARD 100 by OEKO-TEX" стандартын шаардлагыг хангаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын гэрчилгээг 2 дахь жилдээ Ээрмэл утсанд авсан. 2. Англи улсад төвтэй "Тогтвортой ноос ноолуурын эвсэл" / SFA байгууллагын "Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал"-ын тохирлын үнэлгээнд 2 дахь удаагаа амжилттай хамрагдаж "Алтан батламжлал" гардан авсан. 3. Ямааны ноолууран "Н-1, 02, 03, 57 кодтой утас нь химийн будаггүй, цайруулалтгүй ба эдгээр утсаар хийгдсэн сүлжмэл, нэхмэл, оёмол бэлэн бүтээгдэхүүн нь үйлдвэрлэлийн менежмент, чанарын үзүүлэлтүүд органик хөдөө аж ахуй гаралтай бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг ханган "Органик бүтээгдэхүүн" гэрчилгээгээ дахин сунган ажиллаж байна.	Одоогоор эцсийн бэлэн бүтээгдэхүүнд ногоон шошго, гэрчилгээ аваагүй.	GRI 417, SDG 12
MI1	Нөхөн сэргээлт	Нийт ашиглалтын зориулалттай газартай харьцуулахад нөхөн сэргээлт хийсэн газрын талбайн хувь	7%	%	Байгууллагын нийт талбайн 7%-ийг ногоон байгууламжийн талбай эзлэх бөгөөд жил бүр нөхөн тарилт, шинээр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арчилгаа цэвэрлэгээний ажил тогтмол БОМТ-д тусганы дагуу хийгдэж байна.	SDG 15		
CO1	Барилга	Ногоон барилгын шошго/гэрчилгээ	Ногоон барилгын шошго/гэрчилгээ авсан барилгын төслүүдийн хувь	0	%	Байхгүй	GRI 417, SDG 12	
CO2		Хүртээмжтэй байдал	Монгол Улсын хэрэгжиж буй хүртээмжтэй байдлын тухай хууль тогтоомжид нийцсэн барилгын төслүүдийн хувь (үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг мөн харгалзана)	0	%	Байхгүй	SDG 10	
CO3		Ногоон байгууламж, талбай	Монгол Улсын ногоон байгууламж, нийтийн талбайн хууль тогтоомжид нийцсэн барилгын төслүүдийн хувь	0	%	Байхгүй	GRI 304, SDG 15	

БОНЗ-ын тайланг хянасан:
Тогтвортой хөгжил хариуцсан захирал

БОНЗ-ын тайланг боловсруулсан:
Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга

Тогтвортой хөгжлийн менежер

A.Цэрэнтогтох

Э.Ивгээл

Б.Халиун